



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/6218

Улаанбаатар хот

### Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын эх баригчдын нийгэмлэг”-тэй хамтран зохион байгуулах “Эх барихын яаралтай тусламж” сэдэвт сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА



05  
...өдрийн 17 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт  
1218



## “ЭХ БАРИХЫН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ”-ийн сургалтын удирдамж

### Үндэслэл :

Монгол улсын хэмжээнд жил бүр 80000 орчим эх төрж, эхийн эндэгдэл буурч байгаа боловч ноцтой хүндрэлийн тохиолдол төдийлөн буурахгүй байна. Эх барихын ноцтой хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хүндрэлийг оношлох, эмчлэхэд эх баригч нарын үүрэг хариуцлага маш чухал байдаг.

Эх барихын яаралтай тусламжийг хэдийгээр эх баригч нар гардан үзүүлэх боломж төвлөрсөн төрөх газарт харьцангуй бага боловч хөдөө орон нутагт ажиллаж байгаа эх баригч нар эх барихын яаралтай тусламж үзүүлэх тусламж өдөр болгон тохиолдоно.

Эх барихын яаралтай тусламжинд төрсний дараах жирэмсэн үеийн эмгэг, төрсний дараах үеийн хүндрэлүүд түүнчлэн нярайд үзүүлэх яаралтай тусламж өдөр бүр тохиолдоно. Ийм учраас дээрх эмгэгүүдийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх шаардлага амьдралаас урган гарч байна. Үүнд үзүүлэх тусламж эх баригч нараас шаардагдана.

### Зорилго :

Нийслэлийн амаржих газруудад ажиллаж байгаа эх баригч нарт эх барихын яаралтай тусламж үзүүлэх мэдлэгийг сайжруулах, онол практикийн нэгдлийг хангах, ажлын байрны сургалтыг зохион байгуулж бүх эх баригч нарыг хамруулах зорилготой.

### Хамрах хүрээ:

Нийслэлийн Өргөө амаржих газрын нийт эх баригч нар болон яаралтай тусламж үзүүлдэг багийн хамт олон нярайн сувилагч.

### Сургалтын агуулга:

1. Эх баригчийн үзүүлэх яаралтай тусламжийн менежмент, эх баригчийн ажлын байрны тодорхойлолт.
2. Орчин үеийн перинаталь тусламжийн ойлголт.
3. Партограмм хөтлөх.
4. Ургийн зүрхний цахилгаан бичлэг.
5. Жирэмсэн үеийн цус алдалт, их хэмжээний цус алдалтын үед багаар үзүүлэх яаралтай тусламж.
6. Төрөх замын зөөлөн эдийн урагдал, оёдол тавих арга техник.
7. Презклампсийн урьдчилан сэргийлэх оношилгоо, эмчилгээ шокийн үед багаар үзүүлэх тусламж үйлчилгээ.
8. Эмийн гаж нөлөө хүндрэлийн үед үзүүлэх тусламж.
9. Төрсөн эхэд үзүүлэх тусламж үйлчилгээ, эрсдэлээс урьдчилан сэргийлэх.
10. Нярайн бүтэлтийн үед үзүүлэх яаралтай тусламж.

Сургалтын арга зүй : Лекц, практикийн хосолмол сургалт.

**Сургалтын үр дүн :**

Эх баригчдын эх барихын яаралтай тусламж үзүүлэх тусламж үйлчилгээ чанаржиж эхийн эндэгдэл ба ноцтой хүндрэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.


**Багшлах боловсон хүчний бүрэлдэхүүн:**

№	Овог нэр	Албан тушаал	Мэргэжил боловсролын зэрэг
1.	Т.Эрхэмбаатар	АШУҮИС-ын эх барих, эмэгтэйчүүд судлалын тэнхимийн багш, зөвлөх.	АШУ-ны доктор, профессор
2.	С.Алтантуяа	НӨАГ-ийн эх барихын стационарын эрхлэгч	АУ-ны магистр
3.	А.Дүүрэнбилэг	НӨАГ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн их эмч	АУ-ны доктор
4.	Ч.Эрдэнэчимэг	НӨАГ-ийн нярайн эмч	Тэргүүлэх зэргийн эмч
5.	С.Даваасүрэн	МЭБН-ийн тэргүүн, НХАГ-ын сувилахуйн албаны дарга	Сувилахуйн ухааны магистр
6.	Д.Уламбаяр	МЭБН-ийн нарийн бичгийн дарга, НӨАГ-ийн арга зүйч эх баригч	Тэргүүлэх зэргийн эх баригч, сургагч багш
7.	М.Мэндбаяр	НӨАГ-ийн эх баригч	Тэргүүлэх зэргийн эх баригч, сургагч багш
8.	Б.Төмөрчөдөр	НӨАГ-ийн эх баригч	Ахлах зэргийн эх баригч, сургагч багш

**Эх барихын яаралтай тусламж сэдэвт сургалтын хөтөлбөр:**

2018 оны 01 дугаар сарын 18, Пүрэв гараг		
Өргөө амаржих газар хурлын А заал		
13:00-13:10	Бүртгэл	Д. Уламбаяр, Тэргүүлэх зэргийн эх баригч, сургагч багш
13:10-13:25	Нээлтийн үйл ажиллагаа, мэндчилгээ	Т.Эрхэмбаатар, АШУ-ны доктор, профессор
13:25-13:55	Эх баригчийн үзүүлэх яаралтай тусламжийн менежмент, эх баригчийн ажлын байрны тодорхойлолт.	С.Даваасүрэн, МЭБН-ийн тэргүүн, Сувилахуйн ухааны магистр
13:55-14:25	Орчин үеийн перинаталь тусламжийн ойлголт.	С.Алтантуяа, НӨАГ-ийн эх барихын стационарын эрхлэгч
14:25-14:55	Эрсдэлтэй эхчүүдийн партограмм хөтлөх.	Д. Уламбаяр, НӨАГ-ийн арга зүйч эх баригч, Тэргүүлэх зэргийн эх баригч

Ерөнхий захирлын 2017 оны 12 сарын 05 өдрийн  
А/... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт  
218



**“ЭХ БАРИХЫН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ”  
СУРГАЛТЫН ТӨСӨВ**

№	Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Оролцогчдын бичиг хэргийн зардал	ш	60	3000	180000
2.	Цайны зардал	ш	60	3000	180000
3.	Багшийн урамшуулал	Цаг	16	20000	320000
4.	Зохицуулагчийн урамшуулал	Өдөр	2	25000	50000
5.	Сургалтын материал хувилах зардал	Хуудас	40*60	200	480000
6.	Багц цагийн гэрчилгээ	ш	60	1000	60000
7.	Хулдаасан хэвлэл	м <sup>2</sup>	6м <sup>2</sup>	6000	36000
8.	Хөлтэй стэнд	ш	1	24000	24000
9.	Бичиг хэргийн бусад зардал				50000
10.	<b>Бүгд</b>				<b>1380000</b>

Хянасан:

Боловсруулсан:

  
О.Баярсайхан

Д.Гантуяа /Ахлах нягтлан/

О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/